



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙД Ж.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,
<http://www.mojha.gov.mn>

2018. 02. 05. № 1-1/1429
танай 2018. 06. 29-ны № 01/3120 -т

Улсын нэгдсэн бүртгэлд
бүртгэсэн тухай

Танаас ирүүлсэн 2018 оны 01/3120 дугаар албан бичигтэй танилцлаа.

1.Зам, тээврийн хөгжлийн сайд, Байгаль орчин, аялал жуучлалын сайдын хамтран баталсан 2018 оны "Тушаал хүчингүй болгох тухай" 136/A/202 дугаар тушаалыг хүлээн авч, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 3466 дугаарт бүртгэлтэй Зам, тээврийн сайд, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын хамтран баталсан 2014 оны "Журам батлах тухай" /Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн болон экологийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох/ 138/A-208 дугаар тушаалыг улсын нэгдсэн бүртгэлээс хасаж холбогдох хөдөлгөөн хийснийг мэдэгдье.

2.Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны "Журам шинэчлэн батлах тухай" /Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам/ 119 дүгээр тушаалыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзэж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 3957 дугаарт бүртгэснийг мэдэгдье.


Ц.НЯМДОРЖ



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААГ

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2018 оны 06 сарын 09-ны
өдрийн 247 дугаарт бүртгэв.

2018 06 05

119.

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Усан замын тээврийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"-ыг нэгдүгээр, усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээний загварыг хоёрдугаар, усан замын тээврийн хэрэгслийн хувийн хэргийн загварыг гуравдугаар, усан замын тээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэглэгээ, хэмжээг дөрөвдүгээр, усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношлогооны хуудасны загварыг тавдугаар, усан замын тээврийн хэрэгслийн бүртгэлийн маягтын загварыг зургадугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэхүү журмыг хэрэгжүүлж ажиллахыг "Далайн захиргаа" /С. Түвшинтөр/, хяналт тавьж ажиллахыг Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Артур/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Т.Гомбосүрэн/, орон нутгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

САЙД  Ж. БАТ-ЭРДЭНЭ

247
18 06 09 080388

“Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар, гэрчилгээ олгох журам”-ыг шинэчлэн батлуулах тухай танилцуулга

2018.05.07

Монгол Улсад усан замын тээвэр 1950-иад оноос үүсэн хөгжиж, Сэлэнгэ мөрнөөр мод тээвэрлэж, Хөвсгөл нуураар өргөн хэрэглээний бараа, шатах тослох материалыг ОХУ-аас импортлон, мал аж ахуйн гаралтай түүхий эдийг тус улсад экспортолж байсан ч улс орон зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн 1990 оноос хойш ОХУ-аас импортлох бараа, ачаа эргэлт бүрэн зогсож, өмч хувьчлагдсан, хөдлөх бүрэлдэхүүн хуучирсан, мөн байгаль орчны асуудал зэрэг шалтгааны улмаас усан замын тээврийн салбар арав гаруй жил зогссон билээ.

Цөөн тооны хувийн завь бүхий нутгийн иргэд Хөвсгөл нуурт усан замын тээврийн үйлчилгээ 2000 оноос аялал жуулчлалын зориулалтаар эрхэлж эхэлсэн бөгөөд усан замын тээврийн асуудлыг тусгай хуулиар зохицуулах хүртэл Засгийн газрын 2002 оны 40 дүгээр тогтоолоор баталсан “Усан замын тээврийн хэрэгсэлд хяналт тавьж бүртгэх түр журам”-аар усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдал, тээвэрлэлтийн болон техник ашиглалтын шаардлагыг хангуулах, хүн ам, хүрээлэн байгаа байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх нөхцөл бүрдүүлэх чиглэлээр төрийн хяналт тавих, усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг, тооллого явуулж, бүртгэхтэй холбогдсон харилцааг зохицуулж байв.

“Усан замын тээврийн тухай” 2003 онд батлагдсан хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т заасныг хэрэгжүүлэх, усан замын тээврийн хэрэгслийг бүртгэх, бүртгэлийн мэдээллийн сан бий болгох, зорчигч тээврийн үйлчилгээний аюулгүй байдлыг хангах зорилгоор “Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн болон экологийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ыг Зам, тээвэр, аялал жуулчлалын болон Байгаль орчны сайдын хамтарсан 26/58 дугаар тушаалаар 2006 онд батлуулж, мөнхүү журмыг 2014 онд шинэчлэн батлуулж өнөөг хүртэл мөрдөж ирлээ.

Уг журмын дагуу Монгол улсын томоохон гол, мөрөн нууруудад 2017 оны байдлаар улсын хэмжээнд 155 орчим усан замын тээврийн хэрэгсэл тоологдсон ба үүнээс улсын бүртгэлд 111 усан замын тээврийн хэрэгсэл байна. Мөн усан замын тээврийн зорчигч тээвэрлэлт өсч 2017 оны статистикийн мэдээгээр Хөвсгөл нуурт усан замын тээврийн хэрэгслээр 20550 зорчигч тээвэрлэсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсаны дагуу Тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь байгаль орчинд ээлтэй усан замын тээврийг хөгжүүлэхэд анхаарч төрийн байгууллагууд, хувийн хэвшил, иргэд хоорондын уялдаа холбоог сайжруулах эрх зүйн орчин бүрдүүлэх ажлын хүрээнд салбарын гол хууль болох “Усан замын тээврийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг 2017 онд батлуулсан бөгөөд уг хууль мөн оны 07 дугаар сарын 01-нээс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн.

Уг хуульд усан замын тээврийн хэрэгслийн ангилал тогтоох, хөдөлгүүрийн хүчин чадал, уртаас нь хамааруулан улсын бүртгэлд бүртгэх /10-аас дээш морины хүчтэй, 3м-ээс илүү урттай/, усан замын тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг заавал бүртгэх, усан замын тээврийн хэрэгслийн техникийн

2018.05.07
15 08 29

хяналтын үзлэгийг жил бүр хийх, усан замын тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал, зорчигчийн болон жолоочийн амь насны даатгалын асуудал зэрэг зохицуулалтууд шинээр тусгагдсан болно.

Энэхүү шинэчилсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-т “Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ыг усан замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасан нь Зам, тээврийн сайд, Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын хамтарсан 2014 оны 138/А-208 дугаар тушаалаар баталсан “Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн болон экологийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ыг шинэчлэн батлуулах үндэслэл болж байна.

Мөрдөж буй өмнөх журамд усан замын тээврийн хэрэгсэлд техникийн үзлэг, хяналт хийхэд усан замын тээврийн улсын байцаагчдаас гадна, байгаль орчны болон мэргэжлийн хяналтын байгууллагын төлөөллийг оролцуулсан ажлын хэсэг байгуулах, журмын биелэлтэд Улсын мэргэжлийн хяналтын байгууллагын усан замын тээврийн хяналтын байцаагч хяналт тавихаар зохицуулагдсан нь оролцогч байгууллагуудын ажлын уялдааг хангах, цаг хугацаа, төсөв зардал шаарддаг, өөрөөр хэлбэл, оролцогч байгууллагын төлөөллийн зардлыг тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргадаг байв.

Иймээс усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтыг МХЕГ, БОАЖЯ-ны үйл ажиллагаанаас хамааралгүй байлгах үүднээс журмын төслийг шинэчлэн боловсруулсан ба 10 зүйл, 87 заалттай бөгөөд журмыг хэрэгжүүлэхтэй холбогдсон (оношлогооны хуудас, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, бүртгэлийн маягт г.м) баримт бичгийн загварыг батална.

“Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ын шинэчилсэн төсөлд усан замын тээврийн хэрэгслийн бүртгэлтэй холбоотой зохицуулалтаас гадна техникийн хяналтын үзлэг хийх, хөдөлгүүр болон бусад техник, тоног төхөөрөмж, аврах хэрэгсэл зэрэг тээврийн хэрэгслийн бүрэн байдлыг шалгах, усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон хэд хэдэн зохицуулалтуудыг нэмж тусгасан болно. Мөн тоо бүртгэл, техникийн үзлэгт хамруулахад шаардлагатай баримт бичгийн жагсаалтыг үйлчлүүлэгчид аль болох чирэгдүүлэхгүй байхаар журмын төсөлд тусгасан.

“Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ын шинэчилсэн төсөлд гол, мөрөн, нуур бүхий аймгуудын Мэргэжлийн хяналтын газар, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудаас санал авч, ирүүлсэн саналуудыг тусгаж, усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгч иргэд, аж ахуйн нэгж болон завь жолоодогчдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж саналыг тусган Зам, тээврийн хөгжлийн яам болон түүний харьяа Монгол Улсын Далайн захиргааны албан ёсны цахим хуудаст журмын төслийг байршуулж, олон нийтийн санал авах ажлыг Захиргааны ерөнхий хуулийн шаардлагын дагуу зохион байгуулсан болно.

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

247



“Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар, гэрчилгээ олгох журам”-ын шинэчилсэн төсөлд хийсэн нөлөөллийн шинжилгээ

2018.05.07

1. Журам батлуулах үндэслэл, шаардлага

“Усан замын тээврийн тухай шинэчилсэн хууль”-ийн холбогдох заалтыг хэрэгжүүлэх, зорчигч тээвэрлэлт жил бүр өсөн нэмэгдэж байгаатай холбогдуулан усан замын тээврийн хяналтын эрх зүйн орчныг улам сайжруулах шаардлага гарч байна.

“Усан замын тээврийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын 16 дугаар зүйлийн 16.1-д “Усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл түүний эрх олгосон байгууллагаас усан замын тээврийн хэрэгслийн хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх хүчин зүйлсийн зөвшөөрөгдөх хэмжээний түвшин, тээвэрлэлтийн болон техник ашиглалтын дүрмийн шаардлага хангасан байдалд техникийн хяналтын үзлэг жил бүр хийнэ...” гэж, мөнхүү хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-т “Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ыг усан замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж тус тус заасан нь Зам, тээврийн сайд, Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2014 оны 138/А-208 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн болон экологийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ыг шинэчлэн батлуулах хууль зүйн үндэслэл болж байна.

Мөн Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт, “Монгол Улсын сайд эрх хэмжээнийхээ асуудлаар хууль, Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, тэдгээрээс батлан гаргасан бусад шийдвэрт нийцүүлэн тушаал гаргаж, биелэлтийг хангах”, Монгол Улсын Яамны эрх зүйн тухай хуулийн 7.1.1-д “Яам нь сайдын эрхлэх асуудлын хүрээнд хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах” гэж тус тус заасан нь энэхүү журмыг батлах нэгэн үндэслэл юм.

2. Журмын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Энэхүү журмаар усан замын тээврийн үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр эрхлэх, усан замын тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, техникийн аюулгүй ажиллагааг хангах үүднээс тэдгээрт техникийн хяналтын үзлэг хийх, усан замын тээврийн хэрэгслийн тоо бүртгэл хөтлөх, тээврийн хэрэгслийн улсын дугаар, гэрчилгээ олгох, шилжилт хөдөлгөөн хийхтэй холбогдсон харилцааг тус тус зохицуулна.

Шинэчилсэн журмын төсөл нь 10 зүйл, 87 заалттай бөгөөд журмыг хэрэгжүүлэхтэй холбогдсон (оношлогооны хуудас, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, бүртгэлийн маягт г.м) баримт бичгийн загварыг батална.

“Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ын шинэчилсэн төсөлд усан замын тээврийн хэрэгслийн бүртгэлтэй холбоотой зохицуулалтаас гадна техникийн хяналтын үзлэг

18 06 29

хийх, хөдөлгүүр болон бусад техник, тоног төхөөрөмж, аврах хэрэгсэл зэрэг тээврийн хэрэгслийн бүрэн байдлыг шалгах, усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон зохицуулалтуудыг шинээр тусгасан болно.

3. Журмын төсөл батлагдсаны дараа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь аливаа байдлаар хөндөгдөж болохуйц бүлгийг тодорхойлох

Журмын төсөл батлагдсаны дараа усан замын тээврийн хэрэгслээр ажил, үйлчилгээ эрхэлж буй хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг, сонирхол нь ямар нэг байдлаар хөндөгдөхгүй.

Мөн тоо бүртгэл, техникийн үзлэгт хамруулахад шаардлагатай баримт бичгийн жагсаалтыг үйлчлүүлэгчдийг аль болох чирэгдүүлэхгүй байхаар журмын төсөлд тусгасан.

4. Хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх


Энэхүү журмын төсөлд хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига үүсэх нөхцөл бүрдүүлсэн зохицуулалт агуулаагүй болно.

5. Тухайн асуудлыг зохицуулж байгаа урьд нь батлагдсан шийдвэр байгаа эсэх, тушаалыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, санхүү эдийн засгийн тогтолцоо.


Журмын төсөлд тусгагдсан харилцааг өмнө нь Зам, тээврийн сайд, Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2014 оны 138/А-208 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн болон экологийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"-аар зохицуулж байв.

Хуулиар тавигдаж буй шаардлагын дагуу энэхүү журмыг шинээр боловсруулсан бөгөөд түүнийг хэрэгжүүлэхэд хүний нөөц, санхүү, эдийн засгийн зардал шаардагдахгүй болно.

САЙД  Ж.БАТ-ЭРДЭНЭ



Усан замын тээврийн хөгжлийн сайдын
2018 оны 02 дугаар сарын 05 өдрийн
119 тоот тушаалын 1 дүгээр хавсралт



Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх
тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар, гэрчилгээ олгох
журам

1. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь усан замын тээврийн үйл ажиллагааг гол, мөрөн, нуурын экологи, байгаль орчинд сөрөг нөлөөгүй эрхлэхэд төрийн хяналт, зохицуулалтыг чиглүүлж, хүн, хуулийн этгээдийн эзэмшил, өмчлөлд байгаа усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийж хөвөлтийн аюулгүй байдлыг ханган, усан замын тээврийн хэрэгслийн тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар, гэрчилгээ олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийг улсын мэргэжлийн хяналтын байгууллагаас зохих эрх олгогдсон, усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний харъяа байгууллагын усан замын тээврийн хяналтын улсын байцаагчид энэхүү журмыг баримтлан хийнэ.

1.3. Усан замын тээврийн хэрэгслийн тоо бүртгэл хөтлөх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ болон улсын дугаар олгох үйл ажиллагааг усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон байгууллага эрхлэн гүйцэтгэх бөгөөд усан замын тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлж, лавлагаа гаргана.

1.4. Усан замын тээврийн хэрэгслийн осол, зөрчил гарсан болон бусад шаардлагатай тохиолдолд усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх, дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулж болно. Ажлын хэсгийг усан замын тээврийн хяналтын улсын байцаагч ахалж, тухайн орон нутаг дахь холбогдох мэргэжлийн болон хууль хяналтын байгууллагын төлөөллийг оруулж, осол, зөрчлийг шинжлэн шалгаж дүгнэлт гаргана.

1.5. Энэхүү журмын хэрэгжилтэд мэргэжлийн хяналтын байгууллагын усан замын тээврийн хяналтын улсын байцаагчид хяналт тавина.

2. Усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх

2.1. Усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийг жилд нэг удаа усан замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон байгууллага үзлэг оношлогооны болон утааны найрлага хэмжигч зэрэг бусад шаардлагатай багаж хэрэгслээр хийнэ. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус үзлэг хийж болно.

2.2. Усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийг жил бүрийн хөвөлтийн улирал эхэлснээс хойш 14 хоногийн дотор Усан замын тээврийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан техникийн шаардлагын дагуу хийнэ.

2.3. Техникийн хяналтын үзлэгт оруулах усан замын тээврийн хэрэгсэлд Усан замын тээврийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан даатгалыг хийлгэсэн байна.

18.06.2018

2.4. Техникийн хяналтын үзлэгээр усан замын тээврийн хэрэгслийн марк, улсын дугаар, хөдөлгүүрийн дугаар, төрөл, зориулалтыг усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээнд заасан мэдээлэлтэй тулгаж хянах ба усан замын тээврийн хэрэгсэлд зайлшгүй шаардагдах нэмэлт хэрэгслийн /галын хор, ослын дохио, уяа оосор, эмийн сан г.м./ бүрдэл, ашиглалтын шаардлага зэргийг шалгана.

2.5. Техникийн хяналтын үзлэгээр усан замын тээврийн хэрэгсэл нь техникийн дараах шаардлагыг хангаж буй эсэхийг шалгана. Үүнд:

- 2.5.1. Хөдөлгүүрийн ажиллагаа;
- 2.5.2. Хөдөлгүүрээс ялгарч буй утааны бохирдол байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэх;
- 2.5.3. Их биеийн даац, хөдөлгүүрийн багтаамж;
- 2.5.4. Их биеийн бүрэн бүтэн байдал (цоорсон, цуурсан, элэгдсэн эсэх);
- 2.5.5. Шатахууны савны битүүмжлэл, шатах тослох материал алдагдаж буй эсэх;
- 2.5.6. Аврах хантааз нь стандартын болон ашиглалтын шаардлага бүрэн хангаж, зорчигчдын суудлын тоонд хүрэлцэхүйц хэмжээнд байгаа эсэх /хүүхдэд болон том хүнд зориулсан/;
- 2.5.7. Бусад аврах хэрэгсэл болон гал унтраах хэрэгсэл шаардлага хангаж байгаа эсэх;
- 2.5.8. Гэрлэн ба дуут дохионы хэвийн ажиллагаа, бүрэн бүтэн байдал;
- 2.5.9. Ус шавхагч насос хэвийн ажиллагаатай эсэх.

2.6. Усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийлгэхэд дараах баримт бичиг бүрдүүлнэ. Үүнд:

- 2.6.1. Иргэн бол иргэний үнэмлэх, хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ;
- 2.6.2. Усан замын тээврийн хэрэгслийн техникийн паспорт, усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээ, бусад дагалдах баримт бичиг;
- 2.6.3. Усан замын тээврийн хэрэгсэлд их засвар хийсэн бол түүнийг нотолсон баримт бичиг;
- 2.6.4. Усан замын тээврийн хэрэгслийн өмчлөгч солигдсон буюу бусад тохиолдолд хийгдсэн шилжилтийн тухай баримт бичиг;
- 2.6.5. Даатгалд даатгуулсан баримт;
- 2.6.6. Улсын тэмдэгтийн хураамж болон бусад холбогдох албан татварыг төлсөн баримт.

2.7. Усан замын тээврийн хэрэгсэлд ээлжит бус техникийн хяналтын үзлэгийг дараах тохиолдолд хийнэ. Үүнд:

2.7.1. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан усан замын тээврийн хэрэгсэлд зайлшгүй шаардлагаар их засвар үйлчилгээ хийлгэж, хөдөлгүүр сольсон тохиолдолд;

2.7.2. Байгаль орчинд сөргөөр нөлөөлж болзошгүй нөхцөл байдал үүссэн болон хөвөлтийн аюулгүй байдлын шаардлага хангахгүй байгаа талаар иргэдээс санал, гомдол гаргасан тохиолдолд;

2.7.3. Ашиглагдаж байгаад импортоор оруулж ирсэн усан замын тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулна.

247
18 06 29
[Red stamp and signature]

2.8. Техникийн хяналтын үзлэгт тэнцсэн усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношлогооны хуудсанд тухайн техникийн хяналтын үзлэгийг хийсэн эрх бүхий албан тушаалтан, улсын байцаагч гарын үсэг зурж баталгаажуулна.

2.9. Эвдрэл, гэмтлийн улмаас хөвөлтөд гарах боломжгүй усан замын тээврийн хэрэгслийг өмчлөгч, эзэмшигч нь бүртгүүлж, гэрчилгээнд энэ тухай тэмдэглэл хийлгүүлнэ.

2.10. Эвдрэл, гэмтэл болон бусад шалтгаанаар цаашид ашиглах боломжгүй болсон усан замын тээврийн хэрэгслийг ашиглахыг хориглосон тухай тэмдэглэгээг гэрчилгээний "тусгай тэмдэглэл" хэсэгт хийж, гэрчилгээг хураан авна.

2.11. Техникийн хяналтын үзлэг шалгалтын дүнг тэмдэглэсэн усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношлогооны хуудсыг 2 хувь үйлдэж нэг хувийг усан замын тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигчид өгч, нэг хувийг техникийн хяналтын үзлэг хийсэн эрх бүхий албан тушаалтан, улсын байцаагч хадгална.

3. Усан замын тээврийн хэрэгслийг бүртгэх, улсын дугаар, гэрчилгээ олгох

3.1. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан усан замын тээврийн хэрэгслийг өмчлөгч, эзэмшигч хүн, хуулийн этгээдийн хаягаар бүртгэж, харъяалах орон нутгийн нэрийг илэрхийлэх ялгах тэмдэг бүхий улсын дугаар, гэрчилгээ олгоно.

3.2. Өмчлөгч, эзэмшигч нь улсын дугаараас гадна усан замын тээврийн хэрэгсэлдээ нэр өгөх хүсэлт гаргасан бол, түүний санал болгосон нэрийг бусад усан замын тээврийн хэрэгсэлд олгосон нэртэй давхардуулалгүйгээр олгож, хувийн хэрэгт нь тэмдэглэнэ.

3.3. Усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээг баталсан загварын дагуу нууцлалын шаардлагыг хангаж хэвлүүлнэ.

3.4. Усан замын тээврийн хэрэгсэл эзэмшигч, өмчлөгч нь тээврийн хэрэгслийн хувийн хэрэг хөтлөх бөгөөд хувийн хэргийг төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон байгууллага олгоно.

3.5. Усан замын тээврийн хэрэгслийг улсын бүртгэлд шинээр бүртгүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлж, усан замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон байгууллагад ирүүлнэ. Үүнд:

3.5.1. Өмчлөгч, эзэмшигч нь иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар, баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл, хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, албан хүсэлт;

3.5.2. Усан замын тээврийн хэрэгслийн техникийн паспорт, үйлдвэрлэгчийн дагалдах баримт бичиг;

3.5.3. Импортоор оруулж ирсэн бол гаалийн бүрдүүлэлт хийснийг нотолсон баримт бичиг, эсхүл гаалийн байгууллагын тодорхойлолт;

3.5.4. Усан замын тээврийн хэрэгслийг Монгол Улсад үйлдвэрлэж, угсарсан бол түүний аюулгүй байдлыг хянан баталгаажуулсан гаднын мэргэжлийн байгууллагын баримт бичиг;

3.5.5. Усан замын тээврийн хэрэгслийг техникийн үзлэг, оношлогоонд хамруулсан баримт бичиг;

3.5.6. Улсын тэмдэгтийн хураамж болон бусад холбогдох татвар, хураамж төлсөн баримт;

3.5.7. Даатгалд даатгуулсан баримт.

4. Усан замын тээврийн хэрэгслийн тоо бүртгэлд шилжилт хөдөлгөөн хийх

4.1. Дараах тохиолдолд усан замын тээврийн хэрэгслийн тоо бүртгэлд шилжилт хөдөлгөөн, өөрчлөлт хийнэ. Үүнд :

4.1.1. Өмчлөгч, эзэмшигч хүн, хуулийн этгээд нь усан замын тээврийн хэрэгслээ бусдад худалдах, бэлэглэх, солилцох, шилжүүлэх;

4.1.2. Өмчлөгч, эзэмшигч хүн, хуулийн этгээдийн оршин байгаа байршил, хаяг өөрчлөгдөх;

4.1.3. Усан замын тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийг өөрчлөх;

4.1.4. Өмчлөгч хуулийн этгээд татан буугдсан, улсын бүртгэлээс хасагдсан эсхүл өмчлөгч эзэмшигч нас барсан;

4.1.5. Усан замын тээврийн хэрэгслийн өмчлөгч нас барсан тохиолдолд өв залгамжлагчийн, мөн шүүхийн шийдвэрээр усан замын тээврийн хэрэгслийг хураасан буюу шилжүүлсэн бол шийдвэрт заасан хүн, хуулийн этгээдийн нэр дээр тус тус бүртгэнэ.


4.1.6. Татан буугдаж бүртгэлээс хасагдсан хуулийн этгээдийн усан замын тээврийн хэрэгслийг харъяалах нутаг дэвсгэрийн татварын албаны тодорхойлолтыг үндэслэн бусад хүн, хуулийн этгээдийн нэр дээр шилжүүлэн бүртгэж болно.

4.2. Усан замын тээврийн хэрэгслийн тоо бүртгэлд шилжилт, хөдөлгөөн хийлгэхэд дараах баримт бичгийг бүрдүүлж, усан замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон байгууллагад ирүүлнэ. Үүнд:

4.2.1. Хуулийн этгээд хооронд усан замын тээврийн хэрэгслийг шилжүүлбэл шилжүүлэн өгч байгаа хуулийн этгээдийн дарга, захирлын шийдвэр, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, холбогдох татвар хураамж төлсөн баримт болон шилжүүлэн авч байгаа хуулийн этгээдийн дарга, захирлын болон ТУЗ, бүх гишүүдийн хурлын шийдвэр, албан бичиг, гэрчилгээ;

4.2.2. Хуулийн этгээд өөрийн өмчлөлийн усан замын тээврийн хэрэгслийг иргэнд шилжүүлбэл тухайн хуулийн этгээдийн дарга, захирлын болон ТУЗ, бүх гишүүдийн хурлын шийдвэр, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, холбогдох татвар хураамж төлсөн баримт шилжүүлэн авч байгаа хүний үнэмлэх, өргөдөл;

4.2.3. Иргэн өөрийн өмчлөлийн усан замын тээврийн хэрэгслийг хуулийн этгээдэд шилжүүлбэл тухайн иргэний өргөдөл, иргэний үнэмлэх, тээврийн



хэрэгслийн гэрчилгээ, холбогдох татвар хураамж төлсөн баримт, шилжүүлэн авч байгаа хуулийн этгээдийн албан бичиг, гэрчилгээ;

4.2.4. Иргэд хоорондоо усан замын тээврийн хэрэгслээ шилжүүлбэл иргэн тус бүрийн иргэний үнэмлэх, шилжүүлэх өргөдөл, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, холбогдох татвар хураамж төлсөн баримт;

4.2.5. Өмчлөгч иргэн болон хуулийн этгээд тээврийн хэрэгслээ бусдад шилжүүлэхийг хүссэн өргөдөл хуулийн этгээд бол албан бичиг, шийдвэр;

4.2.6. Иргэн, хуулийн этгээдийн хооронд байгуулсан өмчлөлөө шилжүүлсэн гэрээ /нотариатаар гэрчлүүлсэн/;

4.2.7. Даатгуулсан баримт.

4.3. Усан замын тээврийн хэрэгслийн өмчлөгч нас барсан тохиолдолд өв залгамжлалын гэрчилгээ болон хууль ёсны өвлөгчөөр тогтоосон шүүхийн шийдвэрийг үндэслэнэ.

4.4. Усан замын тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийг өөрчилсөн бол тухайн өөрчлөлт нь стандартын шаардлага хангаж байгааг нотолсон техникийн хяналтын үзлэгийн дүгнэлт, өмчлөгчийн хүсэлтийг үндэслэн өөрчлөлтийг бүртгэж, гэрчилгээнд тэмдэглэнэ.

4.5. Өмчлөгч хуулийн этгээдийн улсын бүртгэлээс хасагдсан шийдвэр, татан буугдсан бол үүсгэн байгуулагчийн шийдвэр, хүсэлт, улсын бүртгэлийн байгууллагын тодорхойлолтыг үндэслэнэ.

5. Усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээг нөхөн олгох

5.1. Усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээг үрэгдүүлсэн тохиолдолд нөхөн авахын тулд дараах баримт бичгийг бүрдүүлж, усан замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон байгууллагад ирүүлнэ. Үүнд:

5.1.1. үрэгдүүлсэн гэрчилгээг нөхөн олгохыг хүссэн өмчлөгч /эзэмшигч/-ийн өргөдөл, хуулийн этгээд бол албан бичиг;


5.1.2. үрэгдүүлсэн гэрчилгээг хүчингүйд тооцсон тухай өдөр тутмын сонинд зарлуулсан баримт, сонины зарын хуулбар;

5.1.3. гэрчилгээний үнэ тушаасан баримт.

5.2. Усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээг нөхөж олгосон тохиолдолд гэрчилгээн дээр “нөхөн олгов” гэж тэмдэглэнэ.

5.3. Хэрэглээний явцад хуучирч муудсан, бичлэг тэмдэглэл нь баларч уншигдах боломжгүй болсон гэрчилгээг өмчлөгчийн хүсэлтээр үнийг нь төлүүлэн сольж болно.

6. Усан замын тээврийн хэрэгслийг бүртгэлээс хасах



6.1. Усан замын тээврийн хэрэгслийг техникийн хувьд цаашид ашиглах боломжгүй болсон эсхүл усанд живсэн, экспортлох тохиолдолд өмчлөгч хүн, хуулийн этгээд усан замын тээврийн хэрэгслээ нэг сарын дотор улсын бүртгэлээс хасуулна.

6.2. Усан замын тээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасуулах тохиолдолд дараах баримт бичгийг бүрдүүлж, усан замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон байгууллагад ирүүлнэ. Үүнд:

6.2.1. усан замын тээврийн хэрэгслийг техникийн хувьд цаашид ашиглах боломжгүй болсон, эсхүл экспортлох бол улсын бүртгэлээс хасуулах тухай өмчлөгч хүн, хуулийн этгээдийн хүсэлт, шийдвэр;

6.2.2. Усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээ;

6.2.3. Татварын байгууллагын тодорхойлолт;

6.2.4. Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийсэн улсын байцаагчийн акт, эсхүл усанд живсэн тухай онцгой байдлын байгууллагын байцаагчийн дүгнэлт.

6.3. Байгууллага нь хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор хасалт хийнэ.

7. Усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг

7.1. Усан замын тээврийн хэрэгслийг өмчилж авснаас хойш 14 хоногийн дотор усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон байгууллагад бүртгүүлж улсын дугаар, гэрчилгээ авах буюу шилжилт хөдөлгөөн хийлгүүлнэ.

7.2. Усан замын тээврийн хэрэгслийн улсын дугаарыг баталсан загварын дагуу байршуулж тэмдэглэнэ.

7.3. Усан замын тээврийн хэрэгслийг техникийн хувьд бүрэн бүтэн ашиглах ба түүний техникийн байдалд тогтмол үзлэг хийж, илэрсэн эвдрэл, гэмтлийг тухай бүр засах, өнгө үзэмжийг сайжруулах, усан замын тээврийн хэрэгсэлд засвар, үйлчилгээ хийсэн талаарх тэмдэглэгээг хувийн хэрэгт хийнэ.

7.4. Усан замын тээврийн хяналтын улсын байцаагчийн тавьсан шаардлагыг бүрэн биелүүлж, усан замын тээврийн хэрэгслээ товлогдсон хугацаанд техникийн хяналтын үзлэгт заавал хамруулна;

7.5. Усан замын тээврийн хэрэгслийг шинээр хөвөлтөд гаргах, хөдөлгүүрийг солих буюу их засвар хийсэн тохиолдолд усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон байгууллагад 14 хоногийн дотор мэдэгдэн бүртгүүлэхээс гадна шилжилт хөдөлгөөнийг хийлгэнэ.

7.6. Усан замын тээврийн хэрэгслийн зориулалтыг өөрчлөхгүй.

8. Байгууллагын эрх, үүрэг



8.1. Усан замын тээврийн хэрэгслийн тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар, гэрчилгээ олгох, шилжилт хөдөлгөөн хийх, бүртгэлээс хасах үйл ажиллагааны үнэн зөв байдлыг хариуцна.

8.2. Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн усан замын тээврийн хэрэгслийг бүртгүүлэх, улсын дугаар болон гэрчилгээ авах, шилжилт хөдөлгөөн хийлгэх, бүртгэлээс хасуулах тухай хүсэлт, холбогдох материалыг хүлээж авснаас хойш ажлын 5 хоногийн дотор шийдвэрлэнэ.

8.3. Усан замын тээврийн хэрэгслийг бүртгэж, гэрчилгээ олгохдоо бүртгэлийн карт хөтөлнө.

8.4. Усан замын тээврийн хэрэгслийн бүртгэл, шилжилт хөдөлгөөн хийлгэх, бүртгэлээс хасуулах талаар энэхүү журмын заалтыг зөрчсөн тохиолдолд түүнийг арилгуулах арга хэмжээ авна.

8.5. Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх хугацаа болон хамрагдах нутаг дэвсгэр, байрлалыг өдөр тутмын сонин, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр уг үзлэг явуулахаас 14-өөс доошгүй хоногийн өмнө олон нийтэд урьдчилан мэдээлнэ.

8.6. Усан замын тээврийн хэрэгслүүдийг техникийн хяналтын үзлэгт бүрэн хамруулах ажлын бэлтгэлийг хангах арга хэмжээг авах талаар усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүргийг тухайн орон нутагт хэрэгжүүлж буй байгууллагад мэдэгдэнэ.

9. Усан замын тээврийн улсын байцаагчийн эрх, үүрэг

9.1. Усан замын тээврийн хяналтын улсын байцаагч нь "Бага оворын усан онгоц, завь, катерт техникийн (анхан шатны) үзлэг хийсэн тухай акт" ба "Усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын хуудас"-ыг баримтлан усан замын тээврийн хэрэгслийн үзлэг, хяналтын үйл ажиллагаагаа явуулна.

9.2. Үзлэгт хамрагдсан усан замын тээврийн хэрэгсэл нь техникийн хяналтын шаардлагыг хангаагүй, байгаль орчинд ээлгүй, утаа, химийн аливаа хорт бодис ялгаруулж байгаа тохиолдолд өмчлөгчид доголдол, дутагдлыг арилгах талаар хугацаатай үүргийг өгч тухайн орон нутгийн усан замын тээврийн хяналтын улсын байцаагчид шалгуулан дахин үзлэг хийлгэх арга хэмжээг авах талаар шаардлага тавина.

9.3. Үзлэгээр илэрсэн доголдол, дутагдлыг арилгаагүй болон үзлэгт оруулаагүй усан замын тээврийн хэрэгслийг усан замын хөдөлгөөнд оролцуулахгүй буюу шаардлагатай гэж үзвэл түр саатуулах, мөн хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авна.

9.4. Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийсэн акт буюу дүгнэлтийг ажлын 14 хоногийн дотор тухайн орон нутгийн захиргаанд бичгээр хүргүүлнэ.

9.5. Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийхдээ нийтээр дагаж мөрдөх хууль, тогтоомж, дүрэм, журам, заавар, норм, норматив, стандартыг мөрдөж ажиллах бөгөөд тэдгээр хууль тогтоомжид заасан улсын байцаагчийн бүрэн эрхийн дагуу хяналтыг хэрэгжүүлнэ.

48 06 29

10. Журам зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

10.1. Усан замын тээврийн хэрэгслийг бүртгүүлж, гэрчилгээ авалгүйгээр тээвэрлэлт хийсэн тохиолдолд Усан замын тээврийн тухай хуулийн 19.1.4 дэх заалтын дагуу буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэнэ.

10.2. Техникийн үзлэгт усан замын тээврийн хэрэгслээ хамруулаагүй тохиолдолд Усан замын тээврийн тухай хуулийн 19.1.3 дахь заалтын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

10.3. Усан замын тээврийн хэрэгслийг энэхүү журмын 7.5-д заасан хугацаанд бүртгэл, шилжилт хөдөлгөөнийг хийлгээгүй тохиолдолд Усан замын тээврийн тухай хуулийн 19.1.3 -т заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

11. Бусад


11.1. Усан замын тээврийн хэрэгслийн өмчлөлийн асуудлаар гэр бүлийн гишүүдийн дунд маргаан гарвал Иргэний хуулийн 129 дүгээр зүйл, мөн хуулийн бусад холбогдох заалтыг үндэслэл болгоно.

11.2. Улсын хилээр түр хугацаагаар буцаж гаргах нөхцлөөр оруулсан усан замын тээврийн хэрэгслүүдэд "түр дугаар" олгоно.

---o0o---



Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 06 дугаар сарын 06 бөдрийн тушаалыг үндсэндээ дугаар хавсралт



Усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээний нүүр тал
(арын дэвсгэр өнгө хөх цэнхэр байх ба соёмбо байрлуулна)

САНАМЖ

Усан замын тээврийн хэрэгсэл өмчлөгч, эзэмшигч ТА. Шинээр усан замын тээврийн хэрэгсэл өмчилж авсан бол 14 хоногийн дотор бүртгэх байгууллагад бүртгүүлж гэрчилгээ улсын дугаар авна. Тухайн усан замын тээврийн хэрэгсэлээ ашиглалтаас хассан бол 1 сарын дотор бүртгэх байгууллагад хандах хасалт хийлгэнэ. Өмчлөгч, эзэмшигчийн нэр, хаяг, усан замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөр өөрчлөгдсөн бол 14 хоногийн дотор энэ тухай бүртгэлийн байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ. Усан замын тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэлт хамрагдаагүй бол хөвөлтөд гарахыг хориглоно.

УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН
ХЭРЭГСЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

(MGL)

Дугаар №



Гэрчилгээний дотор тал
(MGL)

Өмчлөгч, эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр

Хаяг _____

Өөрчлөгдсөн тэмдэглэл

Хаяг _____

20 оны сарын -ны өдөр

Өөрчилсөн тэмдэглэл

Хөдөлгөөрийн марк, дугаар

_____ /тэмдэг/
20 оны сарын -ны өдөр

Усан замын тээврийн хэрэгслийн
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Улсын дугаар _____

Нэр _____

Марк _____

Ангилал _____

Зориулалт _____

Үйлдвэрлэсэн он _____

улс _____

Даац _____ урт _____

Зорчигчдын багтаамж _____

Хөдөлгөөрийн багтаамж дугаар _____

_____ Улсад оруулж ирсэн огноо _____

Гэрчилгээ олгосон:

_____ /сарын үсэг/
_____ /тэмдэг/

20 оны сарын -ны өдөр

**ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН
ҮЗЛЭГИЙН ТЭМДЭГЛЭЛ**

Он сар өдөр	Техникийн байдал	Гарын үсэг /тэмдэг/

(засвартай бол хүчингүй)

Тусгай тэмдэглэл

2018 оны 06 сарын 29

Зүүн гар тал

Бага оврын усан онгоц, завь, катерын хувийн хэргийн загвар

№ 000000

Хувийн хэрэг нь бага оврын усан онгоц, завь катерыг өмчлөх /эзэмших/ эрх, Монгол Улсын Төрийн далбаа мандуулан хөвөх эрхийг баталгаажуулж буй баримт бичиг болно.

Улсын дугаар
Өмчлөгч /эзэмшигч/-ийн нэр

Хаяг.....
Байнгын зогсоол

Олгосон:.....
/тэмдэг/ _____ /гарын үсэг/


20... оны ... сарын ... өдөр

Улсын дугаар
Өмчлөгч /эзэмшигч/-ийн нэр

Хаяг.....
Байнгын зогсоол

Олгосон:.....
/тэмдэг/ _____ /гарын үсэг/

20... оны ... сарын ... өдөр



Улсын дугаар
Өмчлөгч /эзэмшигч/-ийн нэр

Хаяг.....
Байнгын зогсоол

Олгосон:.....
/тэмдэг/ _____ /гарын үсэг/

20... оны ... сарын ... өдөр

Их бие

Төрөл, загвар

Үйлдвэрлэгчийн дугаар

Үйлдвэрлэсэн огноо, улс

Материал

Агаарт (хөндий) хайрцаг (хөвөгч блок)-тай эсэх, (м³) ... 247

Ангилалын томъёо



Урт м, өргөн м,
 Хажуу хавирганы өндөр м,
 Хажуу хавирганы уснаас дээшхи хамгийн дээд өндөр м,
 Багтаамж ТОНН
 Зорчигчийн тоо хүн
 Даац тн/кг
 Далбааны талбай м²
 Хөвөх бус, нөхцөл

Хөдөлгүүр	
Төрөл	
Хүчин чадал	
Үйлдвэрийн дугаар	
Улсын байцаагч /гарын үсэг, тэмдэг/	

Хөдөлгүүр	
Төрөл	
Хүчин чадал	
Үйлдвэрийн дугаар	
Улсын байцаагч /гарын үсэг, тэмдэг/	

Хөдөлгүүр	
Төрөл	
Хүчин чадал	
Үйлдвэрийн дугаар	
Улсын байцаагч /гарын үсэг, тэмдэг/	

Бага оврын усан онгоц, завь, катерт заавал байх тоног төхөөрөмж, хэрэгслүүд

1. Дохио өгөх хэрэгслүүд
2. Аврах хэрэгслүүд

5. Хатаах, гал унтраах хэрэгслүүд
6. Зангуу, уяа оосорууд
7. Хангалтын бусад хэрэгслүүд

3. Холбооны хэрэгслүүд

4. Навигацын хэрэгслүүд

Техникийн хяналтын үзлэгт хамрагдаж хөвөлтөд тэнцсэн эсэх тэмдэглэгээ

Огноо	Техникийн байдал	Улсын байцаагчийн гарын үсэг, тэмдэг


Талбар
 18.06.06
 2018.06.06


Зам, тээврийн хөгжлийн сайдын
2018 оны 06 дугаар сарын 05 өдрийн
119 тоот тушаалын дөрөвдүгээр хавсралт

Усан замын тээврийн хэрэгслийн
улсын дугаар, түүнийг тэмдэглэх хэмжээ, байршил

УХА0382
5919487
1116126781

1. Усан замын тээврийн хэрэгслийн улсын дугаар нь төрийн далбаа болон харьяалагдах улс, тухайн орон нутгийн нэрийг илэрхийлсэн гурван үсэг, усан замын тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн дарааллаар нь олгосон цифрээс бүрдэнэ. Цифр нь 01-ээс эхлэх ба цаашид бүртгэгдсэн усан замын тээврийн хэрэгслийн тооноос хамаарч аравт, зуут, мянгатын оронд шилжих маягаар дугаарлагдана.

Жишээ нь:  M01XӨ гэсэн улсын дугаарын M үсэг нь Монгол Улс, 01-хамгийн эхэнд бүртгүүлсэн усан замын тээврийн хэрэгслийн дугаар, XӨ- Хөвсгөл аймаг.




2. Усан замын тээврийн хэрэгсэлд олгосон улсын дугаарыг тухайн тээврийн хэрэгслийн хамрын хоёр хажуу талд, түүний хошуун талаас, их биеийн уртын $\frac{1}{4}$ -тэй тэнцэх хэмжээний зайд, их биеийн дэвсгэр өнгөнөөс тод ялгарах өнгийн будгаар буюу зориулалтын наалт нааж тэмдэглэнэ.

Улсын дугаарын үсэг, тооны өндөр 150 мм-ээс багагүй, өргөн нь 100 мм, зураасны өргөн 15-20 мм байх ба дармал том үсгээр бичнэ. Үсгүүд нь тоонуудаасаа тухайн үсгийн буюу тооны өргөнтэй тэнцүү хэмжээгээр тусгаарлагдсан байна.

Усан замын тээврийн хэрэгслийн зохион бүтээгдсэн онцлогоос хамаарч дээр дурдсан шаардлагыг биелүүлэх боломжгүй тохиолдолд улсын дугаарын хэмжээ 7.6 см-ээс багагүй өндөртэй байх ба дугаар тэмдэглэх байршлыг усан замын тээврийн хяналтын улсын байцаагчаас зөвлөгөө авч тодорхойлно.

УХА0382
5919487
1116126781
18 06 29

119 2018 оны 06 дугаар сарын 05 өдрийн
 тогт тушаалын тус дугаар хавсралт



УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН
 ҮЗЛЭГ, ОНОШЛОГООНЫ ХУУДАС

Дугаар: 1161207
 Огноо: 2018/06/05

Техникийн хяналтын үзлэгт хамрагдаж байсан хугацаа: /анх удаа/
 (он, сар, өдөр)

а. Өмчлөгч, эзэмшигч иргэн, хуулийн этгээдийн талаарх мэдээлэл

Иргэн, ААН, байгууллагын нэр	
Регистрийн дугаар	
Харьяалал /аймаг, сум, хот, дүүрэг/	
Хаяг	
Холбоо барих /утас, цахим шуудангийн хаяг/	

б. Усан замын тээврийн хэрэгслийн техникийн тодорхойлолт

Улсын дугаар		Их биеийн материал	
Нэр		Их биеийн урт, өргөн (м)	
Марк		Ангилал	
Зориулалт		Хажуу хавирганы өндөр (м)	
Үйлдвэрлэсэн он, улс		Хажуу хавирганы уснаас дээшхи хамгийн дээд өндөр (м)	
Монгол Улсад орж ирсэн огноо		Суулт (м)	
Даац (т)		Баиршил	
Зорчигчийн багтаамж (хүн)		(газар, орон нутгийн нэр)	
		Багийн бүрэлдэхүүний тоо	

в. Хөдөлгүүрийн тоо

Үндсэн	Нэмэлт
Төрөл	Төрөл
Хүчин чадал (м/хүч)	Хүчин чадал (м/хүч)
Дугаар	Дугаар
Такт	Такт

г. Техникийн хяналтын үзлэг, оношлогоо


Д/д	Үзүүлэлтүүд	Үнэлгээ	Тайлбар
1	Их биеийн байдал (ерөнхий байдлыг үнэлэх)		
2	Жолоодлогын тоног төхөөрөмж (бүрэн бүтэн байдал, ажиллагааг үнэлэх)		
3	Зангуу буулгах, татах тоног төхөөрөмж уяа оосор (бүрэн бүтэн байдал, ажиллагааг үнэлэх)		
4	Хөвөх чанар, тогтвортой байдал, үл живэх чанар (ерөнхий байдлыг үнэлэх)		
5	Хөдөлгүүрийн хүчин чадлын дээд хязгаар (техникийн баримт бичгээр тогтоосон)		
6	Хөдөлгүүрийн ажиллагаа (ялгарч буй утааны бохирдол байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэх)	CO2 CO HC	
7	Хөдөлгүүрийн аваарын унтраалга Kill cord – Emergency Cut off Switch (бүрэн бүтэн байдал, ажиллагааг үнэлэх)		
8	Шатахууны савны битүүмжлэл (шатах тослох материал алдагдаж буй эсэх)		

18 06 19
 2018 оны 06 сарын 19 ний өдөр


9.	Цахилгааны тоног төхөөрөмж, хэрэгслүүд (бүрэн бүтэн байдал, ажиллагааг үнэлэх)		
10.	Ёроолын ус шавхагч насосын ажиллагаа (бүрэн бүтэн байдал, ажиллагааг үнэлэх)		
11.	Гэрэлтүүлэг, дохионы хэрэгслүүд (нэр төрөл, тоо ширхэг, бүрэн бүтэн байдал, ажиллагааг үнэлэх)		
12.	Механик тоног төхөөрөмж, хэрэгслүүд (ерөнхий байдлыг үнэлэх)		
13.	Холбоо, радио холбооны хэрэгслүүд (төрөл, ажиллагааны бүрэн бүтэн байдал)		
14.	Галын аюулаас урьдчилан сэргийлэх тоног төхөөрөмж, хэрэгслүүд (бүрэн бүтэн байдал, тоо ширхэг, хэрэглэх хугацаа)		
15.	Аврах хэрэгслүүд (нэр төрөл, тоо ширхэг, бүрэн бүтэн байдал, ашиглалтын шаардлага хангасан эсэхийг үнэлэх)		
16.	Хангалтын эд зүйлсийн иж бүрдэл (тоо ширхэг, шаардлагад нийцсэнийг тогтоох)		
Ерөнхий үнэлгээ, дүгнэлт (тэнцсэн, тэнцэхгүй)			
Аялах бүс, нөхцөл:			
Давалгааны өндрийн дээд хязгаар (м)			
Эргээс холдох алслалт (м)			
Хөдөлгүүрийн хүчин чадлын дээд хязгаар (м/хүч)			
Даацын дээд хязгаар (т)			

Техникийн оношлогооны комиссын гишүүн /
(гарын үсэг) (овог нэр, албан тушаал)

Өмчлөгч (эзэмшигч) /
(гарын үсэг) (овог нэр, албан тушаал)



119 Зам тээврийн хөгжлийн сайдын
2018 оны 06 дугаар сарын 05 өдрийн
тоот тушаалын зургадугаар авсралт



УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛИЙН МАЯГ

Дугаар: _____
Огноо 20.../.../...

/Өргөдөл хүлээн авагч байгууллага/

Өргөдлийн агуулга /Холбогдох утгыг сонгоно уу/

1. Шинээр бүртгүүлэх 2. Бүртгэлд шилжилт хөдөлгөөн хийх
 3. Гэрчилгээг нөхөн олгох 4. Хөдөлгүүр өөрчилсөн

Өргөдөл гаргагч иргэн, хуулийн этгээдийн талаарх мэдээлэл

1 Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нэр:	2. Харьяалал /аймаг, сум, хот, дүүрэг/	3. Регистрийн дугаар:
4. Байнгын оршин суугаа хаяг:	5. Холбоо барих утас: _____	
	6. Цахим шуудангийн хаяг: _____	

Өмч хүлээн авагч иргэн, хуулийн этгээдийн талаарх мэдээлэл

/Зөвхөн бүртгэлд шилжилт хөдөлгөөн хийх тохиолдолд бөглөнө/

1 Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нэр:	2. Харьяалал /аймаг, сум, хот, дүүрэг/	3. Регистрийн дугаар:
4. Байнгын оршин суугаа хаяг:	5. Холбоо барих утас: _____	
	6. Цахим шуудангийн хаяг: _____	

Усан замын тээврийн хэрэгслийн техникийн тодорхойлолт

1. Марк _____	6. Үйлдвэрлэсэн он _____ улс _____	
2. Даац _____ кг	7. Ангилал <input type="checkbox"/> жижиг <input type="checkbox"/> дунд <input type="checkbox"/> бага <input type="checkbox"/> том	
3. Зорчигчийн тоо _____	8. Багийн бүрэлдэхүүний тоо _____	
4. Их биеийн хэмжээ Урт _____ м, өргөн _____ м		
5. Их биеийн материал _____		
9. Оноосон нэр:	10. Зориулалт:	11. Үйл ажиллагаа явуулах газар, орон нутгийн нэр:

Хөдөлгүүрийн талаарх мэдээлэл

1 Үндсэн хөдөлгүүр марк _____ хүчин чадал _____ м.х дугаар _____ төрөл _____
2 Нэмэлт хөдөлгүүр марк _____ хүчин чадал _____ м.х дугаар _____

Бүртгэлийн хөдөлгөөн хийх
Зам тээврийн хөгжлийн сайдын
ХУУЛБАР ҮНЭН
2018 оны 06 сарын 29 өдөр

Хөдөлгүүр өөрчлөгдсөн тухай тэмдэглэл /Зөвхөн хөдөлгүүрийг өөрчилсөн тохиолдолд бөглөнө/


марк _____ хүчин чадал _____ м.х дугаар _____ төрөл _____

Өргөдөл гаргасан:

/..... /

Өргөдөл хүлээн авсан тухай тэмдэглэл /Бүртгэгч байгууллагын албан хаагч бөглөнө/

Өргөдлийн дугаар:	Өргөдөл хүлээн авсан				
Огноо:	Нэр	Албан тушаал	Гарын үсэг		
Өргөдөл хавсаргасан баримт бичиг			шинээр	шилжилт хөдөлгөөн	нөхөн олгох
Иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар, хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар					
Усан замын тээврийн хэрэгслийн үйлдвэрлэгчийн техникийн дагалдах баримт бичиг					
Импортоор оруулж ирсэн бол гаалийн бүрдүүлэлтийн мэдүүлэг, эсхүл бүрдүүлэлт хийснийг нотолсон гаалийн байгууллагын тодорхойлолт					
Усан замын тээврийн хэрэгслийг Монгол Улсад үйлдвэрлэж, угсарсан бол түүнийг нотолсон баримт бичиг					
Усан замын тээврийн хэрэгслийг техникийн үзлэг, оношлогоонд оруулсан баримт бичиг					
Улсын тэмдэгтийн хураамж болон бусад холбогдох татвар, хураамж төлсөн баримт					
Хуульд заасан даатгалд даатгуулсан баримт					
Иргэн, хуулийн этгээдийн хооронд байгуулсан өмчлөлөө шилжүүлсэн гэрээ /нотариатаар гэрчлүүлсэн/					
Усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээ					
Усан замын тээврийн хэрэгслийн хөдөлгүүр өөрчлөгдсөн тохиолдолд тухайн өөрчлөлт нь стандартын шаардлага хангаж байгааг нотолсон техникийн хяналтын үзлэгийн дүгнэлт, хүсэлт					
Гэрчилгээг нөхөн олгохыг хүссэн иргэний өргөдөл, хуулийн этгээд бол албан бичиг					
Үрэгдүүлсэн гэрчилгээг хүчингүйд тооцсон тухай өдөр тутмын сонинд зарлуулсан баримт, сонингийн зарын хуулбар					
Хавсралт хуудасны тоо					


 ЗАН ТЭЭВРИЙН ХУУЛБАР ҮНЭМ
 Хуулбар өггөсөн тухай гэрчилгээ
 20 18 оны 06 сарын 20 өдөр